



ДОРНОД АЙМАГ “МЕРИТ” ТӨСӨЛ ХАМТЫН АЖИЛЛАГАА



**МАНЛАЙЛАЛ БОЛОН ИННОВАЦИАР ДАМЖУУЛАН
ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД
ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ
ХУРДАСГАХ ХҮЧ БОЛОХ НЬ**

ДОРНОД

ИЛТГЭГЧ: ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН

2019.01.30





МЭРИТ төсөл нь орон нутгуудаас анх удаа 2016 оноос Дорнод аймагт хэрэгжив





Дорнод аймгийн төлөөлөгчид МЭРИТ төслийн хүрээнд Канад улсад туршлага судлав



-Хийж бүтээснийг 13 хоногийн турш судалж, танилцав

-Эрх зүйн орчин

-Хариуцлагатай уул уурхай,
НӨХӨН СЭРГЭЭЛТ

-Шийдвэр гаргах түвшинд орон нутгийн болон **уугуул иргэдийн оролцоо**

-Баялгийн үр өгөөжийг орон нутагт

-Орон нутгийн эдийн засгийн **ХӨГЖИЛ**





Канад зөвлөхүүд Дорнод аймагт



30 орчим зөвлөх

30 гаруй удаагийн
сургалт, зөвлөн
туслах үйлчилгээг
үзүүлэн, **450**
төрийн албан хаагч
хамрагдав





“Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт”-ыг боловсруулж аймгийн ИТХ-ын 2016 оны 05 дугаар хуралдаанаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна



- Уг урт хугацааны баримт бичигт аймгийн эдийн засгийн хөгжлийн тулгуур салбараар **ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЭРДЭС БАЯЛГИЙН** салбарыг тодорхойлсон байдаг.





ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД
АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ



2015 ОНД /597,7/




368,7 тэрбум

2016 ОНД /676,6/



464,8 тэрбум

2017 ОНД /806,5/



573,8 тэрбум


Жилийн дундаж өсөлт

7,3 хувь





ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР



20,35
мянган тн
алт



15,385
мянган тонн
төмөр



174,16
мянган тонн
зэс



68,56
мянган тонн
уран



505,6
сая тонн
хүрэн нүүрсний
нөөцтэй




Газрын тосны БХГ **19, 21** дүгээр талбайн ашиглалтын баталгаат нийт нөөц газрын тос **34,2** сая тонн,

мөн хар тугалга, барилгын материал, цонхны болон болор шилэн эдлэлийн зориулалттай элс, кварц, шохойн чулуу, өнгөт чулууны орд илэрц цөөнгүй байна.

Дорнод аймаг нь 123.5 мянган км² нутаг дэвсгэртэй, газрын хэвлийн байгалийн эрдэс баялгаар арвин их нөөцтэй. Ашигт малтмалын 85 орд, ирээдүй бүхий 149 илрэлийг тогтоосон бөгөөд 1997 оноос хойш ашигт малтмалын ашиглалт, олборлолт хөгжиж ирсэн.





Тусгай зөвшөөрлийн тоо

НИЙТ
178
593,1 МЯН.ГА
ГАЗАР НУТГИЙН
4.4 %

АШИГЛАЛТ **75**
62.7 МЯН.ГА
ГАЗАР НУТГИЙН 0.5%

ХАЙГУУЛ **93**
476.4 МЯН.ГА
ГАЗАР НУТГИЙН 3,9%

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ
АШИГТ МАЛТМАЛ
9



Салбарын мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй хүргэх зорилгоор www.mining.dornod.gov.mn цахим хаягийг ашиглалтад оруулав.



← → ↻ 🔒 https://mining.dornod.gov.mn

🏠 Нүүр хуудас 👤 Сайтын бүтэц ✉ Холбоо барих

👤 Нэвтрэх & Бүртгүүлэх

🔍 Вэбсайтаас хайх ...

🏠 ЭХЛЭЛ 🏠 САЛБАРЫН ТУХАЙ 📄 МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ 📄 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ 📄 КОМПАНИУД 📄 ТЕНДЕР 📄 ХОЛБОО БАРИХ 🗨️ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 📄 ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

Хариуцлагатай УУЛ УУРХАЙ Амтын ажиллагаа 2018

Иргэдэд өгөөжтэй

Activate Windows
Go to Settings to activate Windows.





ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ НЬ:



Орон нутагт гэрээ байгуулах бодит хэрэгцээ шаардлага:
Орон нутгийн зүгээс баримтлаж буй зарчим:



Уурхайн ажиллагсдын ажиллах, амьдрах орчин стандартын дагуу байх /хүний эрхтэй холбогдоно/



Ажилтан шударгаар сонгон шалгаруулах /сум, орон нутгийн ажилгүйдлийн түвшин, нийгмийн үзүүлэлттэй холбогдоно/



Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн автозам зориулалтын байх /байгаль орчинтой холбогдоно/



БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:



Уурхайн үйл ажиллагаанд шаардагдах бараа, ажил үйлчилгээг ил тод, нээлттэй зарлаж, орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжид давуу эрх олгох /нийгмийн үзүүлэлт, эдийн засгийн хөгжилтэй холбогдоно/





Бид уул уурхайг дэмжинэ, ингэхдээ төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжээс хариуцлага нэхнэ. Хүний эрхийг хангаж, байгаль орчноо хайрлаж, хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхэлж, эргэх холбоотой, хамтын ажиллагаатай байхыг хариуцлага гэж ойлгож байна.



ХҮНИЙ ЭРХИЙГ
ХАНГАЖ



БАЙГАЛЬ ОРЧНОО
ХАЙРЛАЖ



ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН
ХҮРЭЭНД



ЭРГЭХ ХОЛБООТОЙ, ХАМТЫН
АЖИЛЛАГААТАЙ БАЙХ




ХАРИУЦЛАГА


Иймдээ ч өнгөрөгч 2018 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлсэн 16 аж ахуйн нэгжийн удирдлагуудтай 30 орчим удаагийн албан ёсны хэлцлийг зохион байгуулж ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭгээр дамжуулан цаашид хамтран ажиллах чиглэлээ тодорхойлсон юм.





**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ,
2019 ОНООС УУЛ УУРХАЙН АЖ АХУЙН НЭГЖТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ДАГУУ МӨНГӨН
ДЭМЖЛЭГ ТӨВЛӨРНӨ**





ХЭЛЭЛЦҮҮЛЭГҮҮД



**ОРОН НУТГИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ**
боловсруулах ажлын хэсэг өнгөрсөн
зуны турш аймгийн хэмжээний
төрийн болон төрийн бус
байгууллага, уул уурхайн үйл
ажиллагаа явагдаж буй сум багийн
700 гаруй иргэдтэй уулзалт зохион
байгуулж тэдний саналыг нэгтгэн
гэрээнд тусгасан тул гэрээний заалт
бүр нь орон нутгийн иргэдийн
шийдвэрлүүлэхээр бидэнд хандсан
санал гэж ойлгож байна.





Сумын Засаг дарга нар 2018 он хүртэл Аж ахуйн нэгжүүдтэй байгуулж байсан гэрээний ерөнхий загвар



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ

2017 оны 10-ны сарын 18-ны өдөр Дугаар 18 Дашбалбар уул

Энэхүү гэрээг Монгол улсын Иргэний хуулийн 476, 479, 480 дугаар зүйл, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн нэг талаас Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг дарга Баяртогтохын Баттулга /цаашид "Засаг дарга" гэх/, нөгөө талаас 247-А дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч "Шинь Шинь" ХХК-ийн Ерөнхий захирал Ли Зэн /цаашид "компани" гэх/ нар /цаашид хамтад нь "талууд" гэх/ харилцан тохиролцож дараах нөхцөлтэйгээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Дорнод аймаг, Дашбалбар сумын Мардайн нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч "Шинь Шинь" ХХК-ийн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн саналыг тусгасан төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, энэхүү төсөл, хөтөлбөр нь орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалсан, тухайн газар нутгийн хөгжилд хувь нэмэр болохуйц, үр дүнг нь тооцох боломжтой байх зарчимд тулгуурлан хамтран ажиллахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Энэхүү гэрээ нь аймаг, сумын хөгжлийн асуудлаар хамтран ажиллахад чиглэгдэнэ.

1.3. Хамтын ажиллагаа нь хандив, биет хөрөнгө нийлүүлэх болон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хэрэгжинэ.

Хоёр. Засаг даргын хүлээх эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд аймгийн Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1. Компанийн явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллээр тогтмол хангагдаж, шаардлагатай тохиолдолд хуулийн хүрээнд чиглэл өгч биелэлтийг хангуулан ажиллана.

2.1.2. Компанийн үйл ажиллагааны улмаас байгаль орчин, хүн амд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх, урьдчилан сэргийлэхэд анхаарч, хяналт тавина.

2.1.3. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор аймаг, сумын хөгжилд үзүүлэх дэмжлэг, хөрөнгө оруулалтын талаар харилцан тохиролцож, хэрэгжилтийг хангуулна.

2.1.4. Орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр сумын Засаг дарга болон тус компанийн боловсруулсан "Хамтран ажиллах төлөвлөгөө"-г баталсан, хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллана.

2.1.5. Компанийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

3.1.5. Биелэлт, хөрөнгө оруулалтын дүн мэдээг "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлан"-д тусгана.

3.1.6. Уул уурхайн ашиглалт, үйлдвэрлэлийн явцад хууль тогтоомж, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

3.1.7. Байгаль орчныг хамгаалах ажлын хүрээнд уурхайн орчинд байгаа булаг, шандыг хашиж хамгаалах ажлыг хийнэ.

3.1.8. Байгалийн гамшиг осол, гал түймрийн үед нийгмийн хариуцлагын хүрээнд боломжоороо орон нутагт тусалцаа үзүүлнэ.

3.1.9. Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 43.3 дахь заалтуудын дагуу ажлын байрны нөхөн төлбөрийн мөнгийг Төрийн сан банкны 100070500910 тоот дансанд төлөвлөрүүлэх.

3.1.10. Сумын халуун ус саун, хүүхдийн дотуур байрны бохирыг тээвэрлэх 2 тоннын багтаамжтай сав, насосоор хангах

3.1.11. Сумын Иргэний танхимын иж бүрэн засвар тохижилтыг батлагдсан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэх.

3.1.12. Төсвийн тухай хуулийн 23.8.9 заасны дагуу ундны усны төлбөрийг төлөх.

3.1.13. Сумын төв замын дагуу 1.5 км урт 2м өргөнтэй ногоон байгууламжид хашаа, шар хуйс хайлаас тарих, усалгааны системийн үнэ 15 сая төгрөг олгоно.

3.1.14. Монгол улсын нийт нутаг дэвсгэрт хязгаарласан химийн бодис болох циант натрийг хэрэглэхийг хориглоно.

3.1.15. Суманд ажлын байр бий болгох талаар, сумаас 80 доошгүй хүнийг ажлын байраар хангах, тэдний хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллахаас гадна хөдөлмөрийн хөлс цалин хангамжийг одоогийн түвшинээс буулгахгүй.

3.1.16. Сумын 3-аас доошгүй ААНБ-аас мах, махан бүтээгдэхүүн, сүү, аарц-30 тонн, төмс, хүнсний ногоо, өндгийг тогтсон хугацаанд хэрэглээнийхээ хэмжээгээр аймгийн үнээр худалдан авах.

3.1.17. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4.1.4, 12.1.2 дахь заалтуудын дагуу сум орон нутгийн иргэд жижиг дунд үйлдвэрлэлээс мал, мах худалдан авах, сүү сүүн бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо, өндөг бусад бараа бүтээгдэхүүн худалдан авсан 10% ийг Төрийн сан банкны 100070500912 тоот дансанд төвлөрүүлэх.

3.1.18. Гэрээний биелэлт хийсэн ажил, мөнгөний зарцуулалтын талаар 2017 оны 12 дугаар сарын 10-20 өдрийн хугацаанд тайлан тавих.

3.1.19. Сумын Соёлын төвөөс улирал бүр Урлагын арга хэмжээг зохион байгуулах бөгөөд арга хэмжээний зардал 1.5 сая төгрөгийг хариуцах

3.1.20. Суманд зохион байгуулагдаж буй уралдаан, тэмцээнд идэвхитэй оролцож, ажилчдыг хамруулах

3.1.21. Сумын Спорт заалны гадна талын хашаа барихад дэмжлэг үзүүлж материалын үнэ 5.2 сая төгрөг олгоно.

3.1.22. Сумаас боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй 3 оюутан тус бүрийн сургалтын төлбөрт жилд 2.0 сая төгрөг буюу 4 жилд 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх

3.1.23. "Шинь Шинь" ХХК-ийн ажилчдын байр барьвал сумын нутаг дэвсгэрт барина.

Дөрөв. Хамтын ажиллагааны хороо

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г



Сумын Засаг дарга нар 2018 он хүртэл Аж ахуйн нэгжүүдтэй байгуулж байсан гэрээний ерөнхий загвар



Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Тав. Гэрээний хэрэгжилт, хугацаа

5.1. Сумын Засаг дарга, компани нь гэрээний хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас жил тутам тайлагнаж, жилийн эцэст аймгийн Засаг даргаар дүгнүүлнэ.

5.2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэрээний хэрэгжилтийг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгнө.

5.3. Талууд хийсэн ажлынхаа талаар нээлттэй тайлан тавина.

5.4. Гэрээг баталсан өдрөөс эхлэн 2018 оны 2- дүгээр сарын 05-ний өдөр хүртэл хугацаагаар байгуулна.

5.5. Төсөл хэрэгжих хугацаанд гэрээ хүчинтэй.

Зургаа. Гэрээний хариуцлага

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

6.3. Гэрээний үүргээ биелүүлээгүй аль нэг талд эрх бүхий байгууллага, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.2 дахь заалт, бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, үүссэн хохирлыг төлүүлнэ.

6.4. Гэрээ, төлөвлөгөөний дагуу олгогдсон хандив болон биет хөрөнгийг зориулалтын буй зүйл, өөр зориулалтаар зарцуулсан тохиолдолд учруулсан хохирлыг Засаг дарга, буруутай этгээдээс гаргуулна.

6.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн, 5.1-т заасан гэрээний хэрэгжилтийн дүгнэлт хангалтгүй бол аймгийн Засаг дарга гэрээг эргэн харж шинэчлэх эрхтэй.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд талууд зөвшилцөн эвийн журмаар шийдвэрлэнэ.

7.2. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

4

8.1. Талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

8.3. Төсөл үргэлжлэх боломжгүй, ашиггүй болсон болон байгалийн гамшиг, гоц халдварт өвчний хорио цээр зэрэг талууд өөрийн зүгээс хянан зохицуулах боломжгүй хүчин зүйлсийг давагдашгүй хүчин зүйлд тооцно.

8.4. Үйлдвэр ажиллаагүй тохиолдолд энэхүү гэрээний 3.1.9, 3.1.11, 3.1.13, 3.1.15, 3.1.21 дэх заалтууд хамаарахгүй болно.

8.5. Гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР
СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.БАТТУЛГА
(эцэг/эх-ийн нэр, нэр, гарын үсэг, тамга, тэмдэг)

"ШИНЬ ШИНЬ" ХХК-ийн
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ И.ЗЭН
(эцэг/эх-ийн нэр, нэр, гарын үсэг, тамга тэмдэг)

5



Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө



БАТАЛСАН:
 "ШИНЬ ШИНЬ" ХХК-ийн
 ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ *[Signature]*
 Д.ЦЭН
 ДАШБАЛБАР СУМЫН ЗАСАГ
 ДАРГА *[Signature]*
 Б.БАТТУЛГА
 ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМААС "ШИНЬ ШИНЬ" ХХК-ТАЙ
 ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Шаардагдах хөрөнгө	Хариуцах эзэн
1	3.1.7. Байгаль орчныг хамгаалах ажлын хүрээнд уурхайн орчинд байгаа булаг, шандыг хашиж хамгаалах	Жилдээ		БОХУ-ын байцаагч Д.Билгүүн
2	3.1.10. Сумын халуун ус саун, хүүхдийн дотуур байрны бохирыг тэвэрлэх 2 тоннын багтаамжтай сав, насосоор хангах	4 сард		ЕБС-ийн захирал Д.Байгалмаа
3	3.1.11. Сумын Иргэний танхимын иж бүрэн засвар тохижилтыг батлагдсан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэх.	10 сард	30.0 сая төгрөг	ЗДТГ-ын дарга Ү.Бөхчулуун
4	3.1.13. Сумын төв замын дагуу 1.5 км урт 2м өргөнтэй ногоон байгууламжид хашаа, шар хуйс хайлаас тарих, усалгааны системтэй	8 сард	15 сая төгрөг	БОХУ-ын байцаагч Д.Билгүүн
5	3.1.15. Суманд ажлын байр бий болгох талаар, сумаас 80 доошгүй хүнийг ажлын байраар хангах, тэдний хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллахаас гадна хөдөлмөрийн хөлс цалин хангамжийг одоогийн түвшинээс буулгахгүй.	Жилдээ	ЗБАХ	Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Дэлгэрмаа
6	3.1.16. Сумын 3-аас доошгүй ААНБ-аас мах, махан бүтээгдэхүүн, сүү, аарц-30 тонн, төмс, хүнсний ногоо, өндгийг тогтсон хугацаанд хэрэглээнийхээ хэмжээгээр аймгийн үнээр худалдан авах.	Тогтсон хугацаанд	ЗБАХ	МЭҮТ-ийн мэргэжилтэн П.Бор-Охин
7	3.1.17. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4.1.4, 12.1.2 дахь заалтуудын дагуу сум орон нутгийн иргэд жижиг дунд үйлдвэрлэлээс мал, мах худалдан авах, сүү сүүн бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо, өндөг бусад бараа	Хуулийн хугацаанд	ЗБАХ	Татварын байцаагч

6

	бүтэгдэхүүн худалдан авсан 10%-ийг Төрийн сан банкны 100070500912 тоот дансанд төвлөрүүлэх.				
8	3.1.18. Гэрээний биелэлт хийсэн ажил, мөнгөний зарцуулалтын талаар тайлан тавих.	2017 оны 12 дугаар сарын 10-20-ны өдрүүдэд	ЗБАХ	"Шинь Шинь" ХХК	
9	3.1.19. Сумын Соёлын төвөөс улирал бүр Урлагын арга хэмжээг зохион байгуулах бөгөөд арга хэмжээний зардлыг хариуцах	Улирал бүр	1.5 сая төгрөг	Соёлын төвийн захирал	
10	3.1.20. Суманд зохион байгуулагдаж буй уралдаан тэмцээнд идэвхитэй оролцож, ажилчдыг хамруулах	Тухай бүр	ЗБАХ	"Шинь Шинь" ХХК	
11	3.1.21. Сумын Спорт заалны гадна талын хашаа барихад дэмжлэг үзүүлж материалын үнэ олгоно.	8 сард	5.2 сая төгрөг	ЕБС-ийн захирал Д.Байгалмаа	
12	3.1.22. Сумаас боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй 3 оюутан тус бүрийн сургалтын төлбөрт 4 жил дэмжлэг үзүүлэх	8 сард	8.0 сая төгрөг	Нийгмийн ажилтан Т.Нарантуяа	
13	3.1.23. "Шинь Шинь" ХХК-ийн ажилчдын байр барьвал сумын нутаг дэвсгэрт барина.	Тухай бүр	ЗБАХ	"Шинь Шинь" ХХК	

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
 ХШҮ-НИЙ МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Д.ГЭРЭЛМАА

7

Сумын соёлын төвөөс улирал бүр Урлагын арга хэмжээ зохион байгуулах бөгөөд арга хэмжээний зардлыг хариуцах /1.5 сая төгрөг/...г.м



Эрх зүйн үндэслэлүүд:



- а/Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасан “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана”
- б/Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, уурхайтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, үйлдвэр байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх гэрээний загвар” баталсан.





- а/Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших нутгийн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх **төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.**
- /ЗГ-ын 2016 оны 179 дүгээр тогтоол/
- Төсвийн тухай хуулийн 60.2.5-д “Орон нутгийн хөгжлийн сан нь **тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих** зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дэмжлэгээс бүрдэнэ”





Төсвийн тухай хууль:

- 25.4-д “... **төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан** төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно”
- 6.6.2.Төсвийн захирагч нь **төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг** байх
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль:
- 17.3.Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө **өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан** байна.





Газрын тосны тухай хууль:



Газрын тосны тухай хууль:

11.2.17.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах

Сумын
Засаг
дарга

Үндэстэн дамнасан
томоохон
корпорац





Газрын тосны тухай хууль:

31.3. Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг **тухайн орон нутгийн** хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ.

Төсвийн тухай хууль:

- 59 дүгээр зүйл. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан

59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.



Орон нутгаас төрийн захиргааны төв байгууллагад гаргасан санал



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймэг
Утас: 7058-4202, Факс: 7058-4584

2017-12-18 № 1/2017

танай _____ -ны № _____ -т

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮН, УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД
Д.СУМЬЯАБАЗАР ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Таны амгаланг айлтгая.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны нөөц ашигласны төлбөр болон газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмын төсөлтэй танилцлаа.

Төсвийн тухай хууль, Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл болон Засгийн газрын тогтоолоор батлагдах дээрх журмын төсөлд тус тус тусгах, өөрчлөн найруулах саналаа хавсралтаар хүргүүлж байна.

Бидний саналыг хүлээн авч, дэмжин шийдвэрлүүлж өгөхийг Танаас хүсье.

Хавсралт: 8 хуудастай

Хүндэтгэсэн,

ЗАСАГ ДАРГА  М.БАДАМСҮРЭН



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймэг
Утас: 7058-4202, Факс: 7058-4584

2017-12-18 № 1/2017

танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН, МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Таны амгаланг айлтгая.

Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас боловсруулсан Төсвийн тухай хууль, Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны нөөц ашигласны төлбөр болон газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмын төсөлтэй танилцан дараах саналыг Танд хүргүүлж байна.

Бидний саналыг хүлээн авч, дэмжин шийдвэрлүүлж өгөхийг Танаас хүсье.



Хавсралт: 8 хуудастай

Хүндэтгэсэн,

ЗАСАГ ДАРГА  М.БАДАМСҮРЭН

Төсвийн тухай хуулийн
төсөлд тусгахаар
гаргасан санал

Газрын тосны тухай
хуулийн төсөлд тусгахаар
хүргүүлсэн санал





Ажлын хэсгээс шинээр боловсруулсан гэрээ



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

2018 оны 12 сарын 11 өдөр Дугаар: 18/01 Чойбалсан хот

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт /ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана/-ын үндэслэн Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй "Зэст-Өндөр" ХХК-тай нутгийн захиргааны байгууллага харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

1. Ажиллагсадын амьдрах, хөдөлмөрлөх орчин нөхцлийн талаар


- 1.1. Ажилтан ажиллагсдын амьдрах орчин нөхцлийг Монгол улсын холбогдох хууль, тогтоомж дүрэм, журам, стандартад нийцүүлнэ.
- 1.2. Компанид ажиллаж буй Монгол ажилтан, ажиллагсадын цалин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Засгийн газраас баталсан Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарын дундаж цалингаас доошгүй байлгана.

2. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

- 2.1. Аж ахуйн нэгж нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд аймаг, сумын Засаг даргын саналыг тусгана
- 2.2. Ашиглалтын явцад байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, сөрөг нөлөөлөл бий болж, байгаль орчны бохирдол үүссэн тохиолдолд нөхөн сэргээх ажлыг хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж, мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгч, 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж ажиллана.
- 2.3. Уурхайн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртсөн буюу өртөж болзошгүй ард, иргэдийн хохирлыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосны үндсэн дээр нөхөн олговор олгоно.
- 2.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийг чанд мөрдөж ажиллана.
- 2.5. Тусгай зөвшөөрөл бүхий талбайд хог хаягдлын цэг байгуулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг стандартын дагуу чанартай гүйцэтгэнэ.

3. Бүтээгдэхүүн тээвэрлэлт, хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр:

- 3.1. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн хатуу хучилттай автозамын чиглэлийг улс, аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоох асуудлаар талуудын хамтарсан ажлын хэсэг ажиллаж, шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагад шийдвэрлүүлэхээр хандана,



- 3.2. Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн хатуу хучилттай автозамын ажлыг 2020 онд дуусган ашиглалтад хүлээлгэн өгнө, тус автозамын чиглэл өөрчлөгдсөн тохиолдолд 2021 онд барьж ашиглалтад оруулна.

- 3.3. Шаардлагатай тохиолдолд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн автозамын чиглэлтэй уялдуулан иргэдийн зорчих автозамыг засаж сайжруулна

- 3.4. Сүмбэр боомтоор орж ирэх жуулчдын ачаалалтай уялдуулан харилцан тохиролцож бүтээгдэхүүн тээвэрлэлтийг зогсоож болно.

4. Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийг дэмжих:

- 4.1. Бараа бүтээгдэхүүн нийлүүлэх болон үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгохдоо ил тод, нээлттэй тендер зохион байгуулна. Тендерийн шаардлагад нийцсэн нийт аж ахуйн нэгжүүдээс сум, орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт давуу эрх олгоно.

5. Ажиллах хүч сонгох, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

- 5.1. Ажиллах хүчийг аймаг, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, нэгжээр дамжуулан бүртгэлтэй ажил хайгч иргэдээс холбогдох хууль журмын дагуу шударгаар, нээлттэй сонгон шалгаруулж авна. Ингэхдээ тухайн сумын иргэдэд давуу эрх олгоно

- 5.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагатай хамтарч ажиллана.

- 5.3. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулна.

- 5.4. Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлнэ

6. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг:

- 6.1. Нутгийн захиргааны байгууллага нь Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашиглалтын болон тээвэрлэлтийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулахад хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.

- 6.2. Аж ахуйн нэгжээс аймгийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн мөнгөн дэмжлэгийн 30 хувийг ашиглалтын үйл ажиллагаа явагдаж буй тухайн сумын орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ.

- 6.3. Нутгийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлтийг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг нь мэдэгдлээр хүргүүлнэ.

Халхгол сумын
Засаг дарга Х.Хүрэл-эрдэнэ

"Зэст-өндөр" ХХК-ийн гүйцэтгэх
Захирал Ц.Эрдэмжаргал



ЗГ-ын 2016
оны 179 дүгээр
тогтоолоор
батлагдсан
загвар
гэрээний
нэршил,
агуулгын дагуу
боловсруулав



Ажлын хэсгээс шинээр боловсруулсан гэрээ



7. Аж ахуйн нэгжийн эрх, үүрэг:

- Аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу нутгийн захиргааны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх эрхтэй.
- 7.1. Нутгийн захиргааны байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй.
- 7.2. Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар мэдээлэл авах эрхтэй.
- 7.3. Компанийн салбарыг 2019 онд орон нутагт нээж аймгийн Татварын хэлтэст бүртгүүлнэ.
- 7.4. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газрыг компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр тогтмол хангаж ажиллана.
- 7.5. Гамшгийн үед тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад шаардлагатай материаллаг туслалцааг үзүүлнэ.
- 7.6. Сумын ард иргэдэд 4, 10 дугаар саруудад компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүргэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, тэдний санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлэн ажиллана.
- 7.7. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдах салбарын нэгдсэн арга хэмжээнд идэвхи санаачлагатай оролцоно.
- 7.8. Аймгийн уул уурхайн салбарын <http://www.mining.dornod.gov.mn> цахим хаягт компанийн мэдээллийг ил тод байршуулж, шинэчлэлт баяжилт хийх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран гүйцэтгэнэ.
- 7.9. Аж ахуйн нэгж сургалтын хөтөлбөр боловсруулж оюутан, сурагчидад дэмжлэг үзүүлнэ.
- 7.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн хөгжилд дэмжлэг болгож 2018 онд онд 20.000.000 /хорин сая/ төгрөг, 2019 оноос борлуулалтын орлогын 3 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд жил бүр аймгийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлнэ.
- 7.11. Компани 7.11-д заасан мөнгөн дэмжлэгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан аймгийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ.
- 7.12. Аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу нутгийн захиргааны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх эрхтэй.
- 7.13.

8. Хамтын ажиллагааны хороо

- Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г тухайн орон нутгийн иргэдийн төлөөлөл, Нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийг оролцуулан байгуулж ажиллуулна.
- 8.1.

Халхгол сумын
Засаг дарга

Х.Хүрэл-эрдэнэ

"Зэст-өндөр" ХХК-ийн гүйцэтгэх
Захирал

Ц.Эрдэмжаргал

- 8.2. Аймгийн Засаг дарга хорооны ажиллах журмыг батлах бөгөөд бүрэлдэхүүнийг сумын Засаг дарга нэр дэвшүүлж аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

- 8.3. Хороо нь талуудын оролцоог тэгш хангасан 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд иргэдийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ.

9. Гэрээ тайлагнах, дүгнэх

- 9.1. Хамтын ажиллагааны хороо нь гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг аймаг, сумын Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

- 9.2. Гэрээний биелэлтийг дүгнэж, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар тухайн шатны Засаг дарга иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

- 9.3. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

10. Хариуцлага, маргаан шийдвэрлэх

- 10.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу зохих хариуцлага хүлээх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

- 10.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

- 10.3. Талуудын хооронд гэрээтэй холбоотой үл ойлголцол, маргаан үүссэн тохиолдолд харилцан зөвшилцөж эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

- 10.4. Гэрээний 10.3-т заасан арга хэмжээ биелэгдээгүй тохиолдолд шүүхэд гомдлоо гаргаж болно.

Халхгол сумын
Засаг дарга

Х.Хүрэл-эрдэнэ

"Зэст-өндөр" ХХК-ийн гүйцэтгэх
Захирал

Ц.Эрдэмжаргал



Ажлын хэсгээс шинээр боловсруулсан гэрээ



11. Бусад

- 11.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд мөрдөгдөнө
- 11.2. Гэрээнд өөрчлөлт оруулахаар бол талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 11.3. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.
- 11.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.
- 11.5. Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ
ТӨЛӨӨЛЖ:

ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН

ХАЛХГОЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Х.ХҮРЭЛ-ЭРДЭНЭ

Хаяг: Нутгийн удирдлагын ордон
РД: 9029885

АЖ АХУЙН НЭГЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗЭСТ ӨНДӨР ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ЭРДЭМБАЯР

“ЗЭСТ ӨНДӨР” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГАА Н.ЭРДЭМЖАРГАЛ
ХХК


Хаяг: УБ, СБД, 8-р хороо Чингис хаан 5 City
tower 13 давхар
Холбоо барих утас: 80044455

АМТХ-ийн 42 дугаар зүйлийн
42.1-т заасны дагуу гэрээг
нутгийн захиргааны
байгууллага буюу аймаг, сумын
Засаг дарга баталгаажуулсан.
**Аж ахуйн нэгжийн зүгээс
ТУЗ –ийн дарга болон гүйцэтгэх
захирал батлагаажуулсан.**

Талуудын шийдвэр гаргах түвшний төлөөлөл



Орлогын хуваарилалт:



Орлогын хуваарилалтын талаар аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулж байна.





Гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг бүхий хамтын ажиллагааны хороо:



-Хорооны ажиллах журам боловсруулагдсан.

-Гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Хамтын ажиллагааны хорооны үйл ажиллагааны зардлыг 2019 оны орон нутгийн төсвөөс шийдвэрлэв



Та бүхний ажил үйлсэд өндөр амжилт хүсье



БАЯРЛАЛАА